



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 1734

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадад зорчиж байгаа албаны хүмүүсийг угтах, үдэх журам"-ыг хавсралт ёсоор баталж, 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү журмыг төр, засгийн холбогдох байгууллага болон яамны газар, нэгжүүд, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаярт даалгасугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гадаад хэргийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.ЭНХТАЙВАН

Гадаад харилцааны сайдын
2020 оны 08 дугаар сарын 31-ны
өдрийн 1734 дугаар тушаалын хавсралт



ГАДААДАД ЗОРЧИЖ БАЙГАА АЛБАНЫ ХҮМҮҮСИЙГ УГТАХ ҮДЭХ ЖУРАМ

Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар¹ /Цаашид “ДТГ” гэх/ гадаадад зорчиж байгаа төр, засгийн албаны хүмүүсийг угтаж, үдэхдээ дараах журмыг баримтлана. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд тухайн улсад айлчлах, албан болон хувийн хэргээр зорчих, дамжин өнгөрөхөд ДТГ-ын тэргүүн нисэх онгоцны буудалд угтаж, үднэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гэргий/нөхрийн хамт зорчиж байгаа бол ДТГ-ын тэргүүн гэргий/нөхрийн хамт угтаж, үднэ.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гэргий/нөхөр тухайн улсад албан ажлаар зорчих, дамжин өнгөрөхөд ДТГ-ын дэд тэргүүн нисэх онгоцны буудалд угтаж, үднэ. Харин хувийн хэргээр зорчих, дамжин өнгөрөх тохиолдолд ДТГ-ын дипломат ажилтан угтаж, үднэ.

3. Гадаад улс, олон улсын байгууллагын албан ёсны урилгаар, хоёр орны харилцаатай шууд холбоотой албан ажлаар зорчиж байгаа, зөвхөн тухайн ДТГ оршиж буй хотын нисэх онгоцны буудалд, хүлээн авагч улсын холбогдох байгууллагаар угтуулж, үдүүлэхгүйгээр зорчих дараах албаны хүмүүсийг ДТГ угтаж, үднэ. Үүнд:

а. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны ТӨ-III зэрэглэлд² хамаарах (Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч зэрэг) албан тушаалтныг ДТГ-ын дэд тэргүүн, эсхүл дипломат ажилтан;

б. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны ТӨ-IV зэрэглэлд хамаарах улс төрийн (Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд зэрэг) албан тушаалтныг ДТГ-ын дипломат ажилтан;

в. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны ТӨ-IV зэрэглэлд хамаарах тусгай (Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий прокурор), ТӨ-IVA, ТӨ-V, ТӨ-VA, ТӨ-VI, ТӨ-

¹ “6.1. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар тус тус хамаарна.” Дипломат албаны тухай хууль, 2000 он.

² Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан. Мөн 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан.

VIA зэрэглэлд хамаарах болон бусад албан тушаалтныг Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газраас холбогдох чиглэлийг өгсөн тохиолдолд ДТГ-ын дипломат ажилтан, эсхүл ажилтан тус тус угтаж, үднэ.

4. Энэхүү журмын 3-т заасан албан тушаалтнуудын зорчих тухай мэдээллийг холбогдох байгууллагаас Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газарт **зорчих өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө** албан бичгээр урьдчилан мэдэгдсэн байна. Журамд заасан хугацаанаас хожимдуулсан буюу Дипломат ёслолын газраар дамжаагүй тохиолдолд угтаж, үдэхгүй.

5. Дээд, өндөр түвшний айлчлал давхцах зэргээр тухайн ДТГ энэхүү журмын 3-д заасан албан тушаалтнуудыг угтаж, үдэх боломжгүй тохиолдолд энэ тухайгаа ГХЯ-ны Дипломат ёслолын газарт нэн даруй мэдэгдэнэ.

6. Энэхүү журмын 3-ын "а"-д заасан төр, засгийн албаны хүмүүс бусад улсад албан ажлаар очих, буцах замдаа тухайн улсаар дамжин өнгөрөхөд тухайн улсын хилийг нэвтэрч, **8 цагаас дээш хугацаагаар** саатах бол ДТГ-ын дипломат ажилтан нисэх онгоцны буудалд очиж, хүндэтгэл үзүүлнэ.

7. Эдгээр албан тушаалтнуудын дамжин өнгөрөх тухай мэдээллийг холбогдох байгууллагаас Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газарт **зорчих өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө** албан бичгээр урьдчилан мэдэгдсэн байна. Журамд заасан хугацаанаас хожимдуулсан буюу Дипломат ёслолын газраар дамжаагүй тохиолдолд нисэх онгоцны буудалд угтаж, үдэхгүй.

8. ТӨ-I, ТӨ-II зэрэглэлд (Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд) хамаарах албан тушаал хашиж байсан хүмүүсийг зөвхөн Төрийн тусгай хамгаалалтад байх хугацаанд, өөрсдийнх нь хүсэлтийг үндэслэн ДТГ-ын дипломат ажилтан нисэх онгоцны буудалд угтаж, үдэж болно.

9. Энэхүү журмын 1, 2, 3, 8-д заасан албан тушаалтанг нисэх онгоцны буудлын Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх асуудлыг хүлээн авагч тухайн ёслолын дүрэм, журмын дагуу ДТГ-ын тэргүүн зохицуулна. Хүлээн авагч улсын нисэх буудлын Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэхэд төлбөртэй бол энэ талаар ДТГ-аас Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газарт мэдэгдэх бөгөөд тухайн зорчигч, эсхүл байгууллага нь төлбөрийг хариуцна.

10. Энэхүү журмын 3-т заасан албан тушаалтнууд гадаад улс, олон улсын байгууллагын албан ёсны урилгагүй, албан тушаалын чиг үүрэгт нь хамааралгүй, хоёр орны харилцаатай шууд холбоотой бус ажлаар, эсхүл хувийн хэргээр зорчиход ДТГ угтаж, үдэхгүй. Түүнчлэн тухайн албан тушаалтанд болон гэр бүлийн гишүүдэд нь албаны унаагаар үйлчлэхгүй.